
**Улаанбаатар хотын Баянгол дүүргийн нутагт орших
“Хүнд машин механизмын засвар үйлчилгээ, тоног
төхөөрөмжийн худалдаа, сэлбэгийн агуулах” төслийн
2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө**

“БАРЛОВОРЛД МОНГОЛИА” ХХК

ГАРЧИГ

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	3
2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	5
2.1. Төсөл хэрэгжих талбайн физик газарзүйн нөхцөл	5
3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ	7
4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	9
4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	10
4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	13
4.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	14
4.4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	16
4.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	17
4.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	18
Дүгнэлт	20

Зургийн жагсаалт

Зураг 1. Судалгааны талбайн байршил	4
Зураг 2. Судалгааны талбайн физик газарзүйн нөхцөлийн зураг	5
Зураг 3. Агуулахын объект болон хиймэл дагуулын мэдээ	7

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Байгаль орчны шинжилгээ.....	7
Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал .	19

1. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

“Барловорлд Монголиа” ХХК нь 1996 оноос Монгол улсад уул уурхайн тоног төхөөрөмж, сэлбэгийг ханган нийлүүлэх, засварлах, түрээслэх үйл ажиллагаагаа сүүлийн 29 жилийн турш тасралтгүй явуулж байна. Үйл ажиллагаа нь Өмнөговь аймгийн Ханбогд сум, Цогтцэций сум, Гурвантэс сум, Дорноговь аймгийн Замын-Үүд сум зэрэг олон салбартай боловч Улаанбаатар хотын Баянгол дүүрэгт гол үндсэн үйл ажиллагаа явагддаг.

“Барловорлд Монголиа” ХХК нь Улаанбаатар хотын Баянгол дүүргийн хуучнаар 4-р хороо, одоогийн 25-р хорооны нутаг дэвсгэрт нэг доор зэрэгцээ орших доорх 3 хэсэг газарт үйл ажиллагаагаа явуулж байна. Үүнд:

1. Нийслэлийн засаг даргын 2017 оны А/488 тоот захирамжаар олгосон 000001866 тоот газар ашиглах гэрчилгээтэй 7994 м² талбайтай газар
2. Нийслэлийн засаг даргын 2022 оны А/0623 тоот захирамжаар олгосон 0000082889 тоот газар ашиглах гэрчилгээтэй 14741 м² талбайтай газар
3. Өөрийн охин компани болох “Глобал шарын гол” ХХК-ийн эзэмшилд байдаг Нийслэлийн засаг даргын 2021 оны А/104 тоот захирамжаар олгосон 000028842 тоот газар эзэмших гэрчилгээтэй 9268 м² талбайтай газруудад үйл ажиллагаа явуулж байна. Эдгээр 3 хэсэг газрын талбайн нийлбэр 32003 м².

Тус төсөл нь хүнд машин механизмын засвар үйлчилгээ хийж, хүнд машин механизмын тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгсэл худалдаалдаг. Өөрийн гэсэн засвар үйлчилгээний төвтэй. Энэ төвийн зорилго нь уул уурхай болон бусад хүнд үйлдвэрүүдэд шаардлагатай хүнд даацын машин, механизмыг худалдах, сэлбэг хэрэгслийг нийлүүлэх, тэдгээрийн засвар үйлчилгээг хийж гүйцэтгэх юм. Зарим засвар үйлчилгээг хийхэд тухайлбал хөдөлгүүрийн гэмтэл, доголдлыг илрүүлэхэд лабораторид химийн бодис ашиглах шаардлага урган гардаг. Иймээс төсөл хэрэгжүүлэгч нь Катерпилларын S·O·S шингэний шинжилгээний лаборатори байгуулжээ. Катерпилларын S·O·S шингэний шинжилгээний лаборатори нь тосны болон хөргөлтийн шингэний дээжид ашиглалтын шинж чанарын шинжилгээг олон улсын стандартын шаардлагад нийцсэн технологиор хийдэг.

Нийт 300 орчим ажилтантай.

“Хүнд машин механизмын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн худалдаа, сэлбэгийн агуулах” төсөл нь 3 үндсэн хэсэгтэй.

Төв оффис. Энд тус компанийн захирал, удирдах албан хаагчид суух бөгөөд мөн машин механизмын бүхий л засвар үйлчилгээ хийгддэг. Машины мотор болон бусад эд ангиудыг засах засварын цех, машин угаалга зэрэг үйлчилгээ энэ хэсэгт байрладаг.

Түрээс. Машин механизмын зарим жижиг засвар хийгддэг. Мөн цахилгаан үүсгүүр, жижиг машин механизмыг энэ хэсэгт түрээсэлж худалдаалдаг.

Баруун оффис. Тус байранд өөрсдийн худалдан борлуулж буй сэлбэг хэрэгслийг хадгалдаг агуулахтай, мөн оффисын ажилчид суудаг.




Зураг 1. Судалгааны талбайн байршил

2. ТӨСЛИЙН ТАЛБАЙ, ТҮҮНИЙ ОРЧНЫ БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Төсөл хэрэгжих талбайн физик газарзүйн нөхцөл

Судалгааны талбай нь Монгол орны физик газарзүйн мужлалтаар Хангай-Хэнтийн уулархаг их мужийн Хэнтийн мужийн Хэнтийн захын уулсын тойрогт хамаарна. Гадаргын нөхцөлөөр 1230 м өндөрт өргөгдсөн Сэлбэ голын дэнжид байрлана.



Зураг 2. Судалгааны талбайн физик газарзүйн нөхцөлийн зураг

Судалгааны талбайн физик газарзүйн нөхцөл бүрэлдэн тогтоход Туул гол, түүний хажуу жигүүрийн томоохон уул нурууд чухал үүрэгтэй.

Судалгааны талбайн урд чигтээ харагдах Богдхан уул нь зүүнээс баруун тийш чиглэсэн 40 орчим км үргэлжилсэн нуруу юм. Хамгийн өндөр оргил нь далайн түвшнээс дээш 2268 м өндөрт орших Цэцээ гүн юм. Тус ууланд 2000 метрээс дээш өргөгдсөн эртний тэгшрэлийн гадарга голлоно.

Хотын баруун хойд хэсэг нь 1831 м өндөр бүхий Толгойт, 1800 м өндөр бүхий Чингэлтэйн салбар уулсаар хүрээлэгдэнэ. Эдгээр уулс нь харьцангуй мөлгөр

оройтой бөгөөд өвөр хажуу нь аажим намссаар Мааньт, Тасганы овоо, Нарангийн толгодорхог гадаргууд шилжиж үнэмлэхүй өндөр нь багасаж улмаар Туул голын хөндийн хэсэгт тулж очдог. Хотын баруун талд тектоник-дендуцийн гаралтай 1652 м үнэмлэхүй өндөртэй Сонгинохайрхан, зүүн талд 1527 м үнэмлэхүй өндөртэй Баянзүрх уул оршино. Эдгээр уулс нь эгц хажуутай, хурц шовх оройтой, гарш хяруудыг үүсгэсэн байдаг. Дээрх өндөр уулсын муж болон уулс хоорондын хөндийн газрын гадаргын харьцангуй өндөршлийн зөрүү ихэвчлэн 400-500 м боловч заримдаа 700-920 м хүрдэг. Туул голын хөндийн ай савын татмын үнэмлэхүй өндөр 1250-1345 м бөгөөд өргөний хэмжээ 1.2-4.0 км байдаг. Толгойт, Баянхошуу, Баянцогт, Хойд Баян, Цагдуулт зэрэг нам уулсын мужийн үнэмлэхүй өндрийн хэмжээ 1515-1831 м ба тэдгээрийн хажуу ташлаг, энгэр, бэлийн налуу ихэвчлэн 15-20 хэм зарим тохиолдолд 30-35 хэм байдаг. Нэлээд өндөр өргөгдсөн уулсын мужийн хажуу ташлаг, энгэр, бэл, хормойг хөндлөн хэрчсэн олон тооны хуурай сайр, гуу жалга ховил түгээмэл ажиглагддаг.

Улаанбаатар хотын ихэнх барилга байгууламж нь Туул голын хөндийн ай сав болон Сэлбэ голын адаг хэсэг, Зүүн, Баруун Наран, Цагаан хуарангийн дэнжид тархжээ. Түүнчлэн, Туул голын хөндийн өмнөд жигүүрт Их, Бага тэнгэрийн аманд төр, засгийн тусгай объектууд тодорхой хамгаалалтын бүсэд оршдог. Үүний зэрэгцээ Сэлбэ, Хөл, Бэлхийн голын хөндий, Туул голын Дээд Хар усан тохой, Могойн дэнж, Их Хуандай, Улиастай, Гачууртын голын адаг, Толгойтын голын Зүүн, Баруун салаа орчмоор хувийн орон сууцны зориулалттай бэсрэг цогцолбор, зуслангийн барилга байгууламж, гэр хорооллын объектууд нэлээд шигүү хэлбэрээр байрлаж байна (Эко Трейд ХХК, 2006).

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр түүний орчмыг оруулсан байрзүйн дэвсгэр зураг, агаар, сансрын зургийг бэлтгэж, тэдгээр дээр төсөл хэрэгжүүлэх байршил, түүний үйл ажиллагаа явагдах газар, объектуудыг тэмдэглэв.



Зураг 3. Агуулахын объект болон хиймэл дагуулын мэдээ

БОНХСайдын А-117 тоот аргачлалд заасан үзүүлэлтэд үндэслэн тус төслийн үйл ажиллагаанд байгаль орчны шинжилгээ хийж үр дүнг дараах хүснэгтүүдэд үзүүлэв.

Хүснэгт 1. Байгаль орчны шинжилгээ

№	Байгаль орчны шинжилгээ хийх асуултууд	Тийм	Үгүй
Ландшафтын бүрдэл хэсэг болон усан орчин, химийн бодисын хэрэглээний нөлөөлөл			
1	Газрын гадаргын хэв шинжид гарах өөрчлөлт	+	
2	Газар ашиглалтын өөрчлөлт	+	
3	Төсөл хэрэгжүүлэх зориулалтаар усны нөөцийг ашиглах эсэх	+	
4	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх эсэх		+
5	Үл нөхөн сэргэх болон байгалийн ховор нөөц, баялгийг ашиглах эсэх		+
6	Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг ашиглах, хадгалах, тээвэрлэх, устгах үйл ажиллагаа явагдах эсэх	+	
7	Тухайн төслийг хэрэгжүүлэх хүрээнд хүний эрүүл мэнд, байгаль орчинд хор хөнөөлтэй химийн бодис, материалыг үйлдвэрлэх үйл ажиллагаа явагдах эсэх		+
8	Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд хатуу хог хаягдал гарах эсэх	+	
9	Төслийн барилга байгууламжийг барьж байгуулах, төсөл хэрэгжүүлэх болон хаалтын үе шатанд шингэн хаягдал /бохир ус/ гарах эсэх	+	

Орчны бохирдол			
10	Хөдөлгүүрийн хөргүүрийг солих үед хөргөгч шингэн алдагдах эсэх	+	
11	Дугуйны хаягдал үүсэх эсэх	+	
12	Ашигласан тосыг тусгай зориулалтын талбайд хадгалдаг эсэх		+
13	Ашигласан тосыг шатаадаг эсэх		+
14	Хаягдал тосны шүүлтүүрийг дахин ашигладаг эсэх		+
15	Дугуй, ашигласан тос, тосны шүүлтүүр гэм мэт хаягдлыг талбай дээр нь устгадаг эсэх		+
16	Аккумуляторын хаягдлыг талбайд дээр устгадаг эсэх		+
17	Аюултай шинжтэй хог хаягдлыг Монгол улсын Засгийн газрын 264-р тогтоолын дагуу ангилан ахуйн шинжтэй хог хаягдлаас тусад нь хадгалдаг эсэх		+
Эрсдэлийн үнэлгээ			
18	Хүний эрүүл мэнд, аюулгүй байдалд үүсэх эрсдэл	+	
19	Байгаль орчинд үүсэх эрсдэл	+	

4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчин-эдийн засаг

Энэхүү төслийн үйл ажиллагаа нь МУ-ын ЗГ-ын мөрийн хөтөлбөр, Бүс нутгийг хөгжүүлэх бодлого, засаг захиргааны нэгжийн хөгжлийн хөтөлбөр, эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратегийн баримт бичигт тусгагдсан үзэл баримтлалыг хэрэгжүүлэхэд зохих хувь нэмрээ оруулна. Улс орны эдийн засагт дараах хэлбэрээр хувь нэмэр оруулна.

- Ашгийн татвар
- Хүн амын орлогын албан татвар
- Нийгмийн л шимтгэл
- Газар ашигласны төлбөр
- Ус ашигласны төлбөр
- Байгалийн нөөц баялаг ашиглахтай холбогдох татвар, төлбөрүүд

Мөн байгаль орчныг хамгаалах зардлыг жил бүр үндсэн үйл ажиллагааны төсөвт тусгаснаар БОХТ ба ОХШХ-т тусгагдсан арга хэмжээнүүд хэрэгжинэ.

Байгаль орчин-удирдлага зохион байгуулалт

Төсөл хэрэгжүүлэгч “Барловорлд Монголиа” ХХК-ийн нь байгаль орчны мэргэжилтэн эсвэл мэргэжлийн байгууллагатай гэрээлэн ажиллана. Ингэснээр байгаль орчны календарьчилсан төлөвлөгөө гаргаж, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компанийн удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

Байгаль орчны бодлого, зорилго

“Барловорлд Монголиа” ХХК нь экологи-эдийн засгийн тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлэх байгаль орчны бодлогоо дараах хэлбэрээр тодорхойлсон.

- Компанийн бүхий л үйл ажиллагаанд байгаль орчныг хамгаалах асуудал нь чухал ач холбогдолтой байна.
- Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй хэрэгжүүлэх, байгаль орчны үзүүлэлтүүдийг сайжруулах, бохирдлоос урьдчилан сэргийлэх, байгаль орчинд учруулах нөлөөллүүдийг хүрч болох хамгийн бага түвшинд байлгахаар хянана.
- Компанийн байгаль орчны бодлого, зорилт, хэрэгжилт, тэдгээрийн үр дүнг олон нийтэд ил тод, нээлттэй, хүртээмжтэй байна.

4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошг үй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1.	Химийн бодис асгарах	Химийн бодис асгарсан тохиолдолд ажилтнуудын арьс, нүд болон амьсгал хамгаалах зориулалт бүхий стандартын шаардлага хангасан хамгаалалтын хэрэгсэлтэй, асгарсан бодисыг шингээгч оймс (socks), алчуур (pad), дэр (pillow) зэргийг багтаасан АНУ-д үйлдвэрлэгдсэн BOWHEAD Environmental and Safety компанийн тусгай зориулалтын асгаралтын эсрэг иж бүрдэл SPILL RESPONSE KIT-ийг байнгын бэлэн байдалд байлгах	Химийн бодисын агуулах, лаборатори, засварын газар	Иж бүрдэл	3	-	Дотоод зохион байгуулалтаар	Тогтмол	Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
2.	Бодис асгарах, алдагдах	Органик болон органик биш шингэн бодисуудын савны битүүмжлэлийг байнга шалгах	Бодис бүр	Химийн бодисын агуулах	-	-	-	Тогтмол	MNS 6458:2014 Химийн бортой болон аюултай бодисын тухай хууль
3.	Химийн бодис асгарах	Хүчтэй хүчиллэг эсвэл шүлтлэг орчин үзүүлдэг шингэн бодисуудыг	Химийн бодис	-	-	-	-	Асгарсан тохиолдолд	Хог хаягдлын тухай” хууль,

		агуулахын гадна болон дотор асгарсан тохиолдолд нэн даруй шингээгч материалаар шингээн авч аюултай хог хаягдал түр хадгалах саванд хадгалан мэргэжлийн байгууллагаар устгуулах							Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам
4.	Химийн бодис асгарах	Асгарсан хуурай бодисыг тоос үүсгэхээргүй байдлаар цэвэрлэж аюултай хог хаягдал түр хадгалах саванд хадгалан мэргэжлийн байгууллагаар устгуулах	Асгаралт бүрт	-	-	-	-	Асгарсан тохиолдолд	
5.	Агааржуулалт муугаас дотоод орчны агаар бохирдох	Агааржуулалтын системийн найдвартай ажиллагааг хангах, тогтмол шалгах, шаардлагатай үед засвар үйлчилгээг хийх	Лаборатори, агуулах	-	-	-	-	Тогтмол	Агаарын тухай хууль
6.	Байгалийн гамшигт үзэгдэл болон санамсаргүй гал гарах	Галын самбар, гал унтраах хэрэгслүүдийг зохих газруудад байрлуулж галын хоруудыг хугацаанд нь цэнэглүүлж байх	Агуулах, лаборатори, засварын газар, оффис	-	-	-	-	Жилд 1-2 удаа	Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага MNS 5029:2011
7.	Хадгалах хориотой бодисуудыг хамт хадгалсн	Химийн бодисуудыг зөв хаягжуулж, хор аюулын лавлахад заасан зөвлөмжийн дагуу хадгалах	Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	-	-	-	-	Лабораторийн эрхлэгч	

8.	аас эрсдэл үүсэх	Химийн бодисуудыг зөв хаягжуулж, хор аюулын лавлахад заасан зөвлөмжийн дагуу хадгалах	Хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх	-	-	-	-	Лабораторийн эрхлэгч	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
9.	Бохирдсон хог хаягдлаар бохирдол тархах	Химийн бодисын асгарсан тохиолдолд шингээгч материалаар шингээж бохирдсон материалыг мэргэжлийн байгууллагаар устгуулах	Хөрс бохирдох	-	-	-	1,875.0	“Түмэн эгшиг” ХХК-аар устгуулах	MNS 5850:2019 MNS 6458:2014, MNS 5029:2011, MNS 5566:2005
10.	ХААБ алдагдсанаас хүний эрүүл мэнд, амь насанд хохирол учрах	Аюулгүйн ажиллагааны зааварчилгааг боловсруулж агуулахад ажиллагсдыг нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, хөдөлмөр хамгааллын хувцсаар хангах	Лабораторийн ажилчид	хүн	5	-	Дотоод зохион байгуулалтаар	1-р улирал	Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль Хөдөлмөр хамгааллын систем. Галын аюулгүй байдал. Ерөнхий шаардлага” MNS 5029:2011 хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Химийн хорт болон аюултай бодисын шошго, анхааруулах тэмдэг.
11.	Химийн бодисуудыг зөв хадгалах	Химийн хорт болон аюултай бодисуудын Н-аюулын тэмдэглэгээ, Р-анхааруулах тэмдэглэгээ, сэрэмжлүүлэх үг, дүрс тэмдэглэгээнүүдийг багтаасан хаягжуулалтыг агуулахад хадгалагдаж буй бодис нэг бүр дээр бүрдүүлэх	Агуулах	-	-	-	-	2-р улирал	
12.	Нийт зардал, мян.төг						1,875.0		

4.2. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

№	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Орчны тохижилт болон Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих	Тэрбум мод болон орчны тохижилтын хүрээнд мод тарьж ургуулах. Өөрийн эзэмшил газарт тарих талбай байхгүй учир өөр газар тарьж ургуулна.	IC park	ш	200	5.0	1,000.0	Хавар, намар	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль, Газрын тухай хууль Ерөнхийлөгчийн санаачилгаар
2	Нийт, мян.төг						1,000.0		

4.3. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмж их нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг
1	Бүх хог	Үйл ажиллагаанаас гарч буй хог хаягдлыг ангилан ялгаж түр хадгалах - Төмрийн хаягдал - Цаасны хог хаягдал - Хуванцар хаягдал - Тостой хаягдал - Хоол хүнсний хаягдал - Батарей - Мод - Шатах тослох материалын хаягдал - Бусад хаягдал	Бүх хог хаягдал	-	-	-	-	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль
2	Энгийн Энгийн хог хаягдал	Шил лааз, хуванцар сав, цаас, гялгар уут, төмөр, мод гэх мэт дахин ашиглах боломжтой хог хаягдлыг 2-догч түүхий эд авах цэгт тушаах	2-догч түүхий эд	-	-	-	-	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль MNS 5344:2011
3		Дахин ашиглах боломжтой хог хаягдлыг дахин ашиглаж үлдсэн энгийн хог хаягдлыг дүүргийн ТҮК-д нийлүүлэх	-	-	-	-	Гэрээний дагуу	Жил бүр гэрээг сунгах	Хог хаягдлын тухай хууль
4		Хоол хүнсний хаягдлыг бордоо болгох зорилгоор яс	Гал тогооноос	-	-	-	Дотоод зохион	Тухай бүр нь	Хог хаягдлын тухай хууль

		бутлах төхөөрөмж суурилуулах	гарах хаягдал				байгуулалт аар		
6	Аюултай хог хаягдал	Химийн бодис, шатах тослох материалын сав, баглаа боодол, үлдэгдэл, химийн бодис арчсан даавуу, хувцас зэрэг аюултай хог хаягдлыг мэргэжлийн байгууллага болох “Цэцүүх трейд” ХХК- тай гэрээлэн устгуулах	Хөрс, ус бохирдуу лах	кг	-	-	Гэрээний дагуу	Тогтмол	Хог хаягдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
7		Хаягдал тос, тосолгооны материалыг мэргэжлийн байгууллага болох “Хай би ойл” ХХК-аар гэрээлэн устгуулах	Хаягдал тос тосолгоон ы материал						Хог хаягдлын тухай хууль Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль
8	Нийт, мян.төг						-		

4.4. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамж ийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаарын чанар								
1	- PM10 - SOx - NOx - Дуу шуугиан	- Талбайн гадна	1-р улирал	Жилд 1 удаа	75.0	75.0	БОХЗТЛаб	Агаарын тухай хууль MNS 4585:2016
Хөрс								
2	- Агрохими - Хүнд металл	- Ногоон байгууламж бүхий талбай	2-р улирал	Жилд 1 удаа	50.0	50.0	Ланд-Овнер	MNS 5850:2019
Ус								
3	- Анион, катион - Хүнд металл	- Гүний 3 худаг	2-р улирал	Жилд 1 удаа	46.0	138.0	Газарзүй- Геоэкологийн хүрээлэн, Усны газрын лаб	MNS 900:2018 MNS 4943:2015 Усны тухай хууль
4	- Анион, катион - Хүнд металл	- Баруун оффисоос гарах бохир ус - Төв оффисоос гарах бохир ус - Washbay-оос гарах бохир ус	2-р улирал	Жилд 1 удаа	130.0	390.0		
5	Нийт зардал, мян.төг					653.0		

4.5. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилсан төсөв	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
1.	Ус ашиглуулах дүгнэлтийг Нийслэлийн байгаль орчны газраар гаргуулах	50.0	1 улирал	БО-ы мэргэжилтэн	Усны тухай хууль
2.	Дүүргийн ЗДТГ-тай Ус ашиглах гэрээ байгуулах	-	2 улирал	БО-ы мэргэжилтэн	Усны тухай хууль
3.	Хаягдал усны дүгнэлтийг Туул голын сав газраар гаргуулах	-	2 сарын 25 дотор	БО-ы мэргэжилтэн	Усны тухай хууль
4.	Эрх бүхий байгууллагаар Байгаль орчны аудит хийлгэх		3-р улирал	Захирал	Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 10 ¹ .1
5.	Нийгмийн хариуцлагын хүрээнд харьяа хороотой харилцан тохиролцож санал хүсэлтийг шийдвэрлэх	Дотоод зохион байгуулалтаар	Жил бүр	Захирал	БОХТХууль
6.	Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол хийлгэх	Мэргэжлийн байгууллагаар	3-р улирал	Захирал, БО-ы мэргэжилтэн	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль
7.	Нийт зардал, мян.төг	50.0			

4.6. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах

№	БОМТ, БОМТ-ний хэрэгжилтийг тайлагнах оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээний агуулга	Хугацаа	Тайлагнах зардал, мян.төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан
1	БОМТ-ий биелэлтийн тайланг харьяа хороо, байгаль орчны газарт танилцуулах	Хэвлэмэл болон цахим хэлбэрээр	Тухайн жилийн БОМТ-ий хүрээнд, мөн байгаль хамгаалах чиглэлээр хийсэн нэмэлт ажлуудын тухай	11 дүгээр сарын 1	-	Захирал, менежер, БО-ы мэргэжилтэн
2	Нийт зардал, мян.төг	-			-	

Хүснэгт 2. Байгаль орчны менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх зардал

№	Арга хэмжээ	Зардал, мян.төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө	1,875.0
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	1,000.0
3	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	-
4	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	50.0
5	Орчны хяналт шинжилгээ	653.0
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах	-
	Нийт зардал, мян.төг	3,578.0

Дүгнэлт

Улаанбаатар хотын Баянгол дүүргийн нутагт орших “Хүнд машин механизмын засвар үйлчилгээ, тоног төхөөрөмжийн худалдаа, сэлбэгийн агуулах” төслийн 2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **3,578.0** мян.төг зарцуулахаар төлөвлөж байна.